

БАТЛАВ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА БҮМӨНГӨНХҮЯГ
902300604
908892445723007

“ДҮҮРГИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН ШИНЭЧЛЭЛ, ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖ”
(УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ) ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ – БАГЦ 5

2024 оны 04 дүгээр сарын 10

Дугаар 14/14

Улаанбаатар хот

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XV.1.1.51 дүгээр заалт - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн A/246 дугаар эрх шилжүүлэх тухай захирамж
2	Байршил	<p>Нийт 1.163 км авто зам, замын байгууламжийн ажил гүйцэтгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> - 25 дугаар хороо, Алтай хотхоны баруун талаас Мод боловсруулах үйлдвэрийн хойд талын авто зам хүртэлх авто зам - 24 дүгээр хороо, Мод боловсруулах үйлдвэрийн хойд талын авто замаас Энгельсийн гудамж хүртэлх авто зам
3	Ажлын ар хүрээ	<ul style="list-style-type: none"> - Эрх бүхий байгууллагаар батлагдсан авто зам, замын байгууламжийн зураг төслийн дагуу зам барилгын ажлыг гүйцэтгэнэ. - Ажлын зураг төслөөс нарийвчлан үзнэ үү.
4	Төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none"> - Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага
5	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
6	Барилгын ажлын зохион байгуулалт	<p>1. Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил өхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журмын дагуу зөвшөөрөл авна</p> <p>2. Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд гүйцэтгэгч нь ажлын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллана</p> <p>3. Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах, шинээр хийх ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, холбоо, борооны ус зайлзуулах, гэрэлтүүлэг гэх мэт.</p> <p>4. Гүйцэтгэгч нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгууллагатай зөвшилцэж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнэ.</p> <p>5. Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг, тэмдэглэгээ г.м./ыг бүрэн хангаж ажиллана.</p> <p>6. Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях, төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн Засаг даргын албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчтай харилцан зөвшилцэж ажиллана</p> <p>7. Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид,</p>

		<p>нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хулээлгэн өгөх хуртэлх хугацаанд энэ төслөөс өөр төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч хүн хүч, машин механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>8. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна.</p> <p>9. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу гүйцэтгэнэ.</p> <p>10. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчиний графикийг хамтатган батлуулна.</p> <p>11. Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ явганаар зорчиж буй ард иргэдэд саад учруулахгүй байх.</p> <p>12. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэднгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих нөхцөлийг ханган ажиллах, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалтын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай.</p> <p>НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага"-ыг баримтлан гүйцэтгэнэ.</p> <p>13. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>14. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ.</p> <p>15. Зааврын дагуу фото зургаар баталгаажуулаагүй, 7 хоног тутмын тайланд тусгаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалгын метр, рейк, гарас, самбар ашиглана.</p> <p>16. Барилгын ажлын хурзэнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулна.</p>
7	Бусад	Авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН

БГД, ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН
БГД, ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ
АХҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Г. НЯМСҮРЭН